

ИХЭР МӨРӨН АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цэцэрлэг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/107/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Мөрөн сум 2023 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: С.Гансүх

Утас: 95908400 Цахим хаяг: gansukhs@audit.gov.mn

Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал, аудитор Б.Мядагмаа

Утас: 99389208 Цахим хаяг: b_myadagmaaa@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	14
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	17
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

№ 023-02.24 № 01/126
танай _____ -ны № _____ -т

ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Х.ТӨРМӨНХ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цэцэрлэг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цэцэрлэг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх журам"-ын 8.7 дахь заалтад төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн мөнгөн хөрөнгийг улсын төсөвт татан төвлөрүүлэлгүйгээр дараагийн төсвийн жилд шилжүүлэн зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгө данс 106,829.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь 2022 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, суралцагчийн сурлагын чанарыг хараат бусаар үнэлэх, багшийн ажлын үр дүнг суралцагчийн сурлагын чанартай уялдуулж үнэлэх, үр дүн бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудыг шинэчлэн баталж, мөрдүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Сургуулийн захирал Цэцэрлэг сумын Засаг даргатай хийсэн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 14 арга хэмжээг төлөвлөж, 92.7 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *А. Эрдэнэбаатар* А. ЭРДЭНЭБААТАР

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
УИХ	Улсын их хурал
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	277,731,777.66	440,124,321.50
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	106,828,989.34
3121	Төгрөг	00.00	106,828,989.34
31211	Төрийн сангийн харилцах	00.00	106,828,989.34
33	АВЛАГА	00.00	989,100.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	65,100.00
335	Бусад авлага	00.00	924,000.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	924,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	277,731,777.66	332,306,232.16
351	Түүхий эд материал	80,038,628.80	84,428,808.80
35110	Тусгай зориулалттай материал	76,166,506.80	82,105,706.80
35130	Эм боох материал	3,872,122.00	2,323,102.00
354	Хангамжийн материал	197,693,148.86	247,877,423.36
35410	Бичиг хэргийн материал	1,431,238.00	4,712,698.00
35420	Аж ахуйн материал	5,239,622.42	2,340,982.42
35440	Түлш, шатах тослох материал	3,791,550.00	5,003,500.00
35450	Барилгын засварын материал	22,093,500.00	62,688,253.00
35460	Хүнсний материал	55,346,270.00	24,145,125.00
35470	Бусад хангамжийн материал	109,790,968.44	148,986,864.94
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,396,591,241.66	1,336,818,381.91
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,396,591,241.66	1,336,818,381.91
392	Биет хөрөнгө	1,297,896,241.58	1,239,105,381.67
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,196,320,753.00	1,196,320,753.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-347,888,212.08	-406,754,112.76
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	274,393,806.52	355,776,449.43
39206	Хуримтлагдсан элэгдэл	-27,414,745.75	-117,161,624.91
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	166,521,942.76	205,289,138.76
39208	Хуримтлагдсан элэгдэл	-42,919,731.15	-65,270,737.57
39214	Бусад үндсэн хөрөнгө	37,705,700.00	52,705,700.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-4,469,354.52	-9,149,285.28
39217	Ном	45,646,082.80	27,349,101.00
393	Биет бус хөрөнгө	98,695,000.08	97,713,000.24
39301	Програм хангамж	7,085,000.00	7,535,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,239,999.92	-3,671,999.76
39303	Бусад биет бус хөрөнгө	93,850,000.00	93,850,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,674,323,019.32	1,776,942,703.41
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,674,323,019.32	1,776,942,703.41
51	Засгийн газрын хувь оролцоо	1,674,323,019.32	1,776,942,703.41
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,124,890,766.00	1,124,890,766.00
51101	Өмч: - төрийн	1,124,890,766.00	1,124,890,766.00
512	Хуримтлагдсан үр дүн	-253,323,203.42	-150,703,519.33
51210	Өмнөх үеийн үр дүн	-253,323,203.42	-253,323,203.42
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	102,619,684.09
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	802,755,456.74	802,755,456.74
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,674,323,019.32	1,776,942,703.41

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,766,390,106.04	1,972,619,324.41
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	230,003,780.41	161,644,024.41
120	Нийтлэг татварын бус орлого	230,003,780.41	161,644,024.41
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	17,158,529.13	8,561,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	3,785,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	4,776,200.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого/ ҮХ/	00.00	72,192,624.91
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /БМ/	17,158,529.13	80,890,099.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	223,325,625.63	1,810,975,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	1,528,134,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	1,528,134,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,313,060,700.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	23,652,025.63	10,500,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,010,000.00	00.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	8,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,491,425.63	10,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,150,600.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	199,673,600.00	272,340,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	199,673,600.00	272,340,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,548,170,292.57	1,869,999,640.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,548,170,292.57	1,869,999,640.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,503,978,982.57	1,789,835,505.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	939,349,538.00	1,077,657,366.31
210101	Үндсэн цалин	939,349,538.00	798,680,083.35
210102	Нэмэгдэл	00.00	215,550,393.96
210104	Урамшуулал	00.00	63,426,889.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	124,593,771.00	136,078,608.35
210201	Тэтгэврийн даатгал	96,441,893.00	93,072,289.53
210202	Тэтгэмжийн даатгал	7,043,111.00	10,957,403.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,634,489.00	8,368,411.89
210204	Ажилгүйдлийн даатгал	1,406,753.00	2,152,772.36
210205	Эрүүл мэндийн даатгал	14,067,525.00	21,527,730.69
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	190770881.00	195013661.18
210301	Гэрэл, цахилгаан	4,197,181.00	6,290,065.18
210302	Түлш, халаалт	180,223,700.00	180,425,850.00
210303	Цэвэр, бохир ус	6,350,000.00	8,297,746.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,831,597.63	42,345,187.80
210401	Бичиг хэрэг	1,773,247.63	281,360.00
210402	Тээвэр, шатахуун	10,276,740.00	11,622,870.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	965,000.00	00.00
210404	Нөм, хэвлэл	300,800.00	220,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,924,500.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,196,522.00	6,280,300.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	00.00
210408	Бараа материал акталсны зардал	14,394,788.00	910,000.00
2105	Нормативт зардал	70,128,548.00	104,063,565.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,426,812.00	1,692,020.00
210502	Хоол, хүнс	67,452,236.00	102,371,545.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	249,500.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,370,150.00	21,885,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,363,000.00	00.00
210604	Урсгал засвар	6,007,150.00	21,885,100.00
2107	Томилолт, зочны зардал	968,400.00	00.00
210702	Дотоод албан томилолт	968,400.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,256,900.00	12,932,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,656,900.00	4,793,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	8,139,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	128,709,196.94	199,859,916.86
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	14,703,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,939,900.00	8,080,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	122,769,296.94	177,075,716.86
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,191,310.00	80,164,134.82
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,351,600.00	79,548,895.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	36,351,600.00	66,029,395.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	13,519,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	97,519.00	615,239.82
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	97,519.00	615,239.82
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,742,191.00	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,742,191.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	218,219,813.47	102,619,684.09
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал		23,030,057.80
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	00.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	218,219,813.47	102,619,684.09

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,536,386,325.63	1,819,536,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	8,561,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	8,561,300.00

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	8,561,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	3,785,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	4,776,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,536,386,325.63	1,810,975,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	1,528,134,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	1,528,134,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,313,060,700.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	23,652,025.63	10,500,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,010,000.00	00.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	8,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,491,425.63	10,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,150,600.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	199,673,600.00	272,340,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	199,673,600.00	272,340,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,437,285,625.63	1,644,567,320.66
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,437,285,625.63	1,644,567,320.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,393,094,315.63	1,562,182,185.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	939,349,538.00	1,077,657,366.31
210101	Үндсэн цалин	627,122,686.00	796,596,556.35
210102	Нэмэгдэл	251,907,756.00	216,481,194.96
210104	Урамшуулал	60,319,096.00	64,579,615.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	124,593,771.00	136,143,708.35
210201	Тэтгэврийн даатгал	87,524,533.00	92,939,798.53
210202	Тэтгэмжийн даатгал	9,359,543.00	10,890,203.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,393,038.00	8,651,682.89
210204	Ажилгүйдлийн даатгал	1,865,689.00	2,151,092.36
210205	Эрүүл мэндийн даатгал	18,450,968.00	21,510,930.69
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	191,708,981.00	196,225,611.18
210301	Гэрэл, цахилгаан	4,197,181.00	6,290,065.18
210302	Түлш, халаалт	181,161,800.00	181,637,800.00
210303	Цэвэр, бохир ус	6,350,000.00	8,297,746.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27,937,825.63	500,000.00
210401	Бичиг хэрэг	1,952,803.63	00.00
210402	Тээвэр, шатахуун	7,500,000.00	500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	965,000.00	00.00
210404	Ном, хэвлэл	300,800.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,075,422.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,143,800.00	00.00
2105	Нормативт зардал	64,537,000.00	69,859,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	395,400.00	00.00
210502	Хоол, хүнс	63,062,900.00	69,859,400.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,078,700.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,730,300.00	12,794,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,473,200.00	00.00
210602	Тавилга	2,390,000.00	00.00
210604	Урсгал засвар	7,867,100.00	12,794,900.00
2107	Томилолт, зочны зардал	968,400.00	00.00
210702	Дотоод албан томилолт	968,400.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,909,400.00	12,932,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,309,400.00	3,785,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	9,147,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,359,100.00	56,069,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	36,029,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,359,100.00	20,039,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,191,310.00	82,385,134.82
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,351,600.00	81,769,895.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	36,351,600.00	68,250,395.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	13,519,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	97,519.00	615,239.82
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	97,519.00	615,239.82
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,742,191.00	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,742,191.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	99,100,700.00	174,969,279.34
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	99,100,700.00	68,140,290.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	99,100,700.00	68,140,290.00
2200	Дотоод эх үүсвэрээр	99,100,700.00	68,140,290.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	99,100,700.00	68,140,290.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-99,100,700.00	-68,140,290.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	106,828,989.34
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	106,828,989.34

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,124,890,766.00	802,755,456.74	-471,543,016.89	1,456,103,205.85
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,124,890,766.00	802,755,456.74	-471,543,016.89	1,456,103,205.85
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	218,219,813.47	218,219,813.47
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,124,890,766.00	802,755,456.74	-253,323,203.42	1,674,323,019.32
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,124,890,766.00	802,755,456.74	-253,323,203.42	1,674,323,019.32
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,124,890,766.00	802,755,456.74	-253,323,203.42	1,674,323,019.32
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	102,619,684.09	102,619,684.09
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,124,890,766.00	802,755,456.74	-150,703,519.33	1,776,942,703.41

2.5.1 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Улсын төсөв/

/Төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,537,095,800.00	1,429,866,810.66	107,228,989.34	93.02
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,537,095,800.00	1,429,866,810.66	107,228,989.34	93.02
210	Бараа, үйлчилгээний зардал	1,452,663,400.00	1,348,096,915.66	104,566,484.34	92.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,086,387,300.00	1,022,093,926.31	64,293,373.69	94.08
210101	Үндсэн цалин	810,597,200.00	745,743,062.35	64,854,137.65	92.00
210102	Нэмэгдэл	234,183,500.00	214,580,084.96	19,603,415.04	91.63
210104	Урамшуулал	41,606,600.00	61,770,779.00	(20,164,179.00)	148.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	135,798,400.00	129,002,099.35	6,796,300.65	95.00
210201	Тэтгэврийн даатгал	92,342,900.00	87,985,310.87	4,357,589.13	95.28
210202	Тэтгэмжийн даатгал	10,863,900.00	10,307,324.38	556,575.62	94.88
210203	ҮОМШӨ ний даатгал	8,691,100.00	8,212,259.36	478,840.64	94.49

210204	Ажилгүйдлийн даатгал	2,172,800.00	2,045,199.73	127,600.27	94.13
210205	Эрүүл мэндийн даатгал	21,727,700.00	20,452,005.01	1,275,694.99	94.13
2105	Нормативт зардал	102,099,400.00	69,859,400.00	32,240,000.00	68.42
210502	Хоол, хүнс	102,099,400.00	69,859,400.00	32,240,000.00	68.42
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	14,184,700.00	13,382,100.00	802,600.00	94.34
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,785,100.00	3,785,100.00	-	100.00
210806	Мэдээллийн технологийн зардал	10,399,600.00	9,597,000.00	802,600.00	92.28
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	114,193,600.00	113,759,390.00	434,210.00	99.62
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	98,594,100.00	98,159,890.00	434,210.00	99.56
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,599,500.00	15,599,500.00	-	100.00
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	84,432,400.00	81,769,895.00	2,662,505.00	96.85
2132	Бусад урсгал шилжүүлэг	84,432,400.00	81,769,895.00	2,662,505.00	96.85
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг	70,912,900.00	68,250,395.00	2,662,505.00	96.25
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	13,519,500.00	13,519,500.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,537,095,800.00	1,536,695,800.00	400,000.00	99.97
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,528,134,500.00	1,528,134,500.00	-	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,528,134,500.00	1,528,134,500.00	-	100.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	8,961,300.00	8,561,300.00	400,000.00	95.54
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,785,100.00	3,785,100.00	-	100.00
1E+06	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,176,200.00	4,776,200.00	400,000.00	92.27
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	106,828,989.34	(106,828,989.34)	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	85.00	85.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	49.00	49.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	35.00	35.00	-	100.00

2.5.2 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Орон нутгийн төсөв/

/Төгрөгөөр/

	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
1					
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	272,340,800.00	271,725,560.18	615,239.82	99.77
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	272,340,800.00	271,725,560.18	615,239.82	99.77
210	Бараа, үйлчилгээний зардал	272,340,800.00	271,725,560.18	615,239.82	99.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	55,563,600.00	55,563,440.00	160.00	100.00
210101	Үндсэн цалин	55,563,600.00	50,853,494.00	4,710,106.00	91.52
210102	Нэмэгдэл	-	1,901,110.00	(1,901,110.00)	-
210104	Урамшуулал	-	2,808,836.00	(2,808,836.00)	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,141,800.00	7,141,609.00	191.00	100.00
210201	Тэтгэврийн даатгал	4,954,500.00	4,954,487.66	12.34	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	582,900.00	582,879.50	20.50	100.00
210203	ҮОМШӨ ний даатгал	439,500.00	439,423.53	76.47	99.98
210204	Ажилгүйдлийн даатгал	105,900.00	105,892.63	7.37	99.99
210205	Эрүүл мэндийн даатгал	1,059,000.00	1,058,925.68	74.32	99.99
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	196,840,500.00	196,225,611.18	614,888.82	99.69
210301	Гэрэл цахилгаан	6,899,700.00	6,290,065.18	609,634.82	91.16
210302	Түлш, халаалт	181,640,800.00	181,637,800.00	3,000.00	100.00
210303	Цэвэр, бохир ус	8,300,000.00	8,297,746.00	2,254.00	99.97
2106	Эд хогшил худалдан авах	12,794,900.00	12,794,900.00	-	100.00
210604	Урсгал засвар	12,794,900.00	12,794,900.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	272,340,800.00	271,725,560.18	615,239.82	99.77
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	272,340,800.00	271,725,560.18	615,239.82	99.77
132001	Орон нутгийн төсвөөс	272,340,800.00	271,725,560.18	615,239.82	99.77
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	85.00	85.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	49.00	49.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	35.00	35.00	-	100.00

2.5.3 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Нэмэлт төсөв/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-

2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,500,000.00	10,500,000.00	100.00
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	10,500,000.00	10,500,000.00	100.00
210	Бараа, үйлчилгээний зардал	10,500,000.00	10,500,000.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	500,000.00	500,000.00	100.00
210402	Тээвэр (шатахуун)	500,000.00	500,000.00	100.00
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	10,000,000.00	10,000,000.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,000,000.00	10,000,000.00	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	10,500,000.00	10,500,000.00	100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,500,000.00	10,500,000.00	100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,500,000.00	10,500,000.00	100.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

1.6.1 Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Цэцэрлэг сумын ерөнхий боловсролын сургууль нь бага болон суурь, дунд боловсрол олгох сургалтын үйл ажиллагаа явуулдаг Боловсрол Шинжлэх Ухааны Яамны харьяа байгууллага юм.

Сургуулийн үйл ажиллагааны үндсэн зорилт нь суралцагчдад боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх, тэдний хөгжих, төлөвших үйл явцыг шинжлэх ухааны үндэстэй удирдах, зохион байгуулах, эцэг, эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, тэдэнд мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа дэмжлэг үзүүлэхэд оршино.

2022 онд “Эрүүл зөв дадал, эерэг хандлага, бүтээлч оролцоог хэвшүүлж сургалтын чанарыг дээшлүүлнэ” гэсэн зорилго тавьж ажилласан ба энэхүү зорилгын хүрээнд багш, сургууль, суралцагч, эцэг эхийн хөгжилд чиглэсэн зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.

Сургуулийн захирал Цэцэрлэг сумын Засаг даргатай хийсэн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 14 арга хэмжээг төлөвлөж, 92.7 хувьтай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: 2022 онд боловсролын салбарт шинэчлэл хийж, түүнийг дэмжсэн төсвийг батлан хэрэгжүүлэхийг зорьсон байна. Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийг 2021 онд өөрчлөн найруулснаар гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бий болгож, “хувьсах зардал”-ыг улсын төсвөөс санхүүжүүлэх болсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн "Төрийн хэмнэлтийн тухай" хууль хэрэгжиж эхэлсэн.
3. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.
4. Боловсролын салбарт хийж байгаа шинэчлэл, үйл ажиллагаа, төсөв санхүүг дэмжсэн шийдвэрийг Засгийн газар, салбарын яамнаас гаргаж мөрдүүлсэн байна. Тухайлбал:
 - Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газрыг байгуулсан ба 2022 оны 131 дүгээр тогтоолоор Боловсролын ерөнхий газрын даргыг Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын, мэргэжлийн боловсролын, техникийн боловсролын сургалтын байгууллагын төсвийн төвлөрүүлэн захирагчаар баталсан байна.
 - Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор "Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчдад хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн", "Төрийн болон орон нутгийн өмчит цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын байршил, хэв шинж, хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүр", "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал" баталсан байна.
 - БШУС-ын 2022 оны А/122 дугаар тушаалаар Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолыг үндэслэн төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоосон.
 - БШУС-ын 2022 оны А/170 дүгээр тушаалаар "төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээл сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх хуваарилах заавар"-ыг 1 дүгээр, "багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих, үйл ажиллагааны санхүүжилт, түүнийг зарцуулах заавар"-ыг 2 дугаар, "цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах заавар"-ыг 3 дугаар, "тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг төлөвлөх хуваарилах, санхүүжүүлэх зааврыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсан байна.
 - БШУС-ын 2022 оны А/259 дүгээр тушаалаар "Цэцэрлэг, ерөнхий боловсролын багшийг эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоонд хамруулах заавар"-ыг баталсан байна.
 - БШУС-ын 2022 оны А/430 дугаар тушаалаар багшийн ажлыг үнэлэх журмыг шинэчлэн баталсан.
 - БШУС-ын 2022 оны А/452 дугаар тушаал "Хувьсах зардлын тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын тухай"
 - БШУС-ын 2022 оны А/465 дугаар тушаал " Ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах нийтлэг журам"
 - БШУС-ын 2022 оны А/500 дугаар тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн

чанар, үр дүнг үнэлж, үр дүнгийн нэмэлт урамшууллын зардлыг санхүүжүүлэхэд баримтлах чиглэлийг баталсан.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ийн дагуу сургуулийн захирлын 2021 оны А/09 тоот тушаалаар дотоод хяналт хэрэгжүүлэх ажлын хэсгийг 3 хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 1 дүгээр сард батлуулан, тухайн онд нийт 5 удаа дотоод хяналтыг хэрэгжүүлж, тайлагнасан боловч дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлэх, хяналтаар илрүүлсэн зөрчил, дутагдлыг арилгахад чиглэсэн үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай байна гэж үзлээ.

Түүнчлэн 2022 онд сургуулийн захирлын тушаалаар шинээр гарсан дүрэм, журмуудын хэрэгжилтийг хангах, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, төсөв санхүүг зарцуулах, түүнд хяналт тавих, худалдан авах ажиллагааг зохион байгуулах, шинээр гарсан дүрэм, журмын хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий зөвлөл, ажлын хэсэг, багуудыг томилж ажиллуулсан байна.

Тус сургууль нь 2022 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 64 дүгээр тогтоолоор төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогыг зохион байгуулсан байна.

Эдгээр зохион байгуулалтын арга хэмжээний хүрээнд байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны дотоод хяналтын 1 ба 2 дугаар үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд Хөвсгөл аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2019-2021 онуудын тайланд нийцлийн аудит хийсэн байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цэцэрлэг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар: Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа БСШУС-ын 2017 оны А/40 дүгээр тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэнтэй холбоотойгоор нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цэцэрлэг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 102,619.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	-	106,829.0	(106,829.0)
Авлага	-	989.1	(989.1)
Бараа материал	277,731.8	332,306.2	(54,574.4)
Үндсэн хөрөнгө	1,396,591.2	1,336,818.4	59,772.8
Нийт хөрөнгө	1,674,323.0	1,776,942.7	(102,619.7)
Өр төлбөр	-	-	
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,674,323.0	1,776,942.7	(102,619.7)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,674,323.0	1,776,942.7	(102,619.7)

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, эздийн өмчийн данс өмнөх оноос нэмэгдэж, үндсэн хөрөнгө буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 106,829.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь цалин хөлс, бараа үйлчилгээний бусад зардлаас 74,589.0 мянган төгрөг, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх хоолны зардлаас 32,240.0 мянган төгрөгийн үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүй нь гол нөлөө үзүүлсэн байна.
2. Авлага дансны үлдэгдэл НДШ- 65,1 мянган төгрөг тогтвортой хөгжил 2 төслийн шатахууны үнэ 924.0 мянган төгрөгийн авлага нөлөөлсөн байна.
3. Бараа материал данс өмнөх оноос 54,574.4 мянган төгрөгөөр өссөн нь УИХ гишүүн Л.Мөнхбаатар /гурвын эсрэг гурав төрлийн сагсан бөмбөгийн талбай байгуулахад зориулж 48,304.9 мянган төгрөг, Эгшиглэн магнай ХХК-аас 1,585.4 мянган төгрөгийн морин хуур, сумын орон нутгийн хөгжлийн сангаас 28,400.0 мянган төгрөгийн “Хүүхдийн орчинд өнгө нэмье” төслийн хүрээнд үнэ төлбөргүй бараа материал хүлээн авсан нь нөлөөлсөн байна.
4. Үндсэн хөрөнгө данс 59,772.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 140,332.9 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, үндсэн хөрөнгийн элэгдэл 175,075.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Улсын төсвөөс санхүүжих зардлын төлөвлөлт:

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,631,716.1 мянган төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн ба төсвийн төслийн саналаас 374,787.7 мянган төгрөгөөр бууруулан 1,256,928.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн жилийн дундуур төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэрээр төсвийн хуваарьт дараах байдлаар өөрчлөлт оруулсан байна. Үүнд: БШУС-ын 2022 оны 3 дугаар сарын 24-

ны А/105 тоот тушаал, 2022 оны 10 дугаар сарын 7-ний өдрийн А/258 дугаар тушаал, 12 дугаар сарын 30-ны өдрийн А/392 тоот тушаалаар тус тус өөрчлөлт оруулж, анхны баталсан төсвийг 271,206.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлжээ.

Ингэснээр нийт төсвийн зарлагыг 1,537,095.8 мянган төгрөгөөр, үүнээс 1,528,134.5 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэх, 8,961.3 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоор санхүүжүүлэхээр баталсан байна.

Орон нутгийн төсвөөс санхүүжих зардлын төлөвлөлт:

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд орон нутгийн төсвөөс 473,375.5 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөж, Цэцэрлэг сумын ЗДТГ-т хүргүүлснийг сумын ИТХ-ын хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 03 дугаар тогтоолоор 359.454.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Энэ нь төсвийн төслийг байр ашиглалтын тогтмол зардлаар тооцоолсныг байр ашиглалтын үйлчилгээний зардлаар нэмэгдүүлэн баталсантай холбоотой.

Цэцэрлэг сумын ИТХ-ын 2022 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн хуралдааны 05 тоот тогтоолоор тус сургуулийн төсөвт тодотгол хийж, 87,113.6 мянган төгрөгөөр бууруулан 272,340.8 мянган төгрөгөөр баталсан нь төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин, шимтгэлийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх болсонтой холбоотой.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр 1,429,866.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, 271,725.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, нэмэлт санхүүжилтээс 10,500.0 нийт 1,712,092.4 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авсан байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлого 8,961.3 мянган төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 8,561.3 мянган төгрөгийн төвлөрүүлж, 95.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

Орон нутгийн төсвөөс санхүүжих зардлын гүйцэтгэл 100 хувьтай, төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдэгдэл 615.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлсэн.

Улсын төсвөөс санхүүжих зардал 93,6 хувийн гүйцэтгэлтэй, зарцуулагдаагүй үлдэгдэл 106,829.0 мянган төгрөг харилцах дансанд үлдэгдлээр байршиж байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Улсын төсвөөс санхүүжих					
1	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	4,159.9	4,159.9	-	-
2	80312-Сургалт семинар	2,079.9	2,079.9	-	-
3	81605-Эрүүл мэндийг дэмжих	4,783.8	4,783.8	-	-
4	81801-Үдийн цай хөтөлбөр	70,912.9	68,250.4	2,662.5	96.2
5	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	55,445.0	55,443.8	1.2	100
	81806-Дотуур байр	151,351.5	115,501.6	35,849.6	76.3
6	81823-Боловсролын байгууллагын багш, ажилчдын мэргэжил дээшлүүлэх	9,359.7	9,326.7	33.0	99.6
7	81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх	1,049,659.4	986,285.7	63,373.7	94.0
8	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа	180,382.4	175,473.7	4,908.7	97.3
9	81844	176.2	176.2	-	-
10	81848	3,785.1	3,785.1	-	-
11	83603	5,000.0	4,600.0	400.0	92.0
Дүн		1,537,095.8	1,429,866.8	107,229.0	93.0

Орон нутгийн төсвөөс					
1	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	209,635.4	209,020.5	614,9	99.70
2	80112-Нийтлэг үйлчилгээ	62,705.4	62,705.0	0.4	99.99
Дүн		272,340.8	271,725.5	615.3	99.77
Нийт дүн		1,809,436.6	1,701,592.3	107,844.3	94.03

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Цэцэрлэг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн аудитор Б.Мядагмаа гүйцэтгэж, анхан шатын хяналтыг аудитор Ц.Мөнхтуяа хийж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Гансүх, аудитын менежер Б.Тэгшдэлгэр нар хоёр дахь шатанд, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар дараагийн шатны хяналтыг хэрэгжүүлсэн.

Цэцэрлэг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,548,170.3 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 30,963.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд төсвийн байгууллагын авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 30 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хэмнэлтийн горимыг баримталж, хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дагавар нь төрийн үйл ажиллагааны чанар, хүртээмжийг бууруулахгүй байх зарчмыг баримтлан ажилласан ба улсын төсвийн мэдээлэл технологийн зардал, бараа үйлчилгээний бусад зардлаас 106,829.0 мянган төгрөг хэмнэж дансны үлдэгдлээр үлдсэн, орон нутгийн төсвөөс гэрэл цахилгаан, урсгал засварын зардлаас 615.2 мянган төгрөгийг хэмнэж орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Цэцэрлэг сумын ерөнхий боловсролын сургуулийн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавьсан мэдээллийг хянаж үзэхэд 2022 онд нийт 151 мэдээлэл оруулахаас 146 мэдээлэл хугацаандаа мэдээлж, 5 мэдээллийг оруулах хугацаа болоогүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Цэцэрлэг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хэрэгжүүлээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	13.0	2	13.0	100.0
Албан шаардлага	2	69.3	2	69.3	100.0
Нийт дүн	1	82.3	4	82.3	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар төсвийн жил дамжин хэрэгжиж байгаа сургалтын үйл ажиллагаа, хувьсах зардлын нөхөн хангалтаар авч байгаа тоног төхөөрөмжийг хүлээн авч, орлогод авсан эсэх, сургуулийн үйл ажиллагаанд ашиглахаар худалдан авч байгаа сургуулийн удирдлагын цогц системийн ашиглалтад анхаарах шаардлагатай гэж үзлээ.

Харилцах дансны үлдэгдлийн 106,829.0 мянган төгрөгийн зарцуулалтыг дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн алдаа зөрчил байхгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.